

Орхондалай ХК ний бүх гишүүдийн хурлын

Тэмдэглэл.

2021 оны 4 сарын 30.

Бэлэндалай.

Компаний бүх гишүүдийн хурал 2021 оны 4 сарын 30 ны өдрийн 14 цагт компаний байрнаас удирдан zoom апплекейшн ашиглан цахимаар хуралдлаа. Хуралд

1. С.Бүрэнбат	74766 хувьцаа	30,1 хувь
2. Б.Баярхүү	52304 хувьцаа	21,6 хувь
3. Ө.Батсайхан	39649 хувьцаа	16,4 хувь
4. Г.Нарантуяа	11620 хувьцаа	4,8 хувь

Нийт 4 хувь эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн 75,9 хувийн ирцтэй хурал хуралдлаа.

Хурлаар хэлэлцүүлэх асуудлууд:

1. Компаний 2020 оны үйл ажиллагааны тайлан хэлэлцэж дүгнэх
2. Компаний 2020 оны санхүүгийн аудитлагдсан тайланг хэлэлцэж дүгнэх
3. Бусад асуудлууд

Компаний гүйцэтгэх захирал Б.Нямбаяр:

Хувь эзэмшигч та бүхэнд өдрийн мэнд хүргэж мэндчилье. Улс даяар ковид-19 цар тахалын нөхцөл байдал хүнд байгаа учраас анх удаа цахим хэлбэрээр хурлаа зохион байгуулж байна. Сүлжээний нөхцөл байдлаас шалтгаалан тасалдах нөхцөл үүсч магадгүй дурдлаа.

2020 онд Орхондалай ХК тариалангийн үйлдвэрлэлээ бэлтгэл сайн хангаж бага хүний нөөцөөр чанартай ажиллаж төлөвлөсөн зардлаас хэтрүүлэхгүй, үйл ажиллагааны эрсдэлгүй сахилга баттай хичээж ажиллалаа. Компаний ажиллагсад дундаж наслалт 39, хоёр механикжуулагч, нэг механик, нэг менежер, нэг тогооч үйлчлэгч, гэрээгээр талбайн харуул нэг, үтрэмийн ажилтан хоёр ажиллаж байна. Хүмүүсийн үр чадвар, хариуцлага хэвийн, хээрийн нөхцөлд байрлан хүнс хоол, тамхи, хөдөлмөр хамгааллын хувцас, бусад ахуйн зүйлээр ханган ажиллав. Харилцан ойлголцож нөхцөл байдлыг хангаж ажиллаж байгаа болохоор тогтвор суурьшилтай байна. Харин технологийн ажилтан буюу механикжуулагчид нас ахимаг болж цаашид шинэ тракторч комбайнч, гагнуурчин засварчин бэлтгэн авах зайлшгүй шаардлага гарч байна.

Техник тоног төхөөрөмжийн хувьд одоогийн эзэмшиж байгаа талбайд 60\ 40 харьцаатай тариалалт уринш гэсэн сэлгээгээр ажиллахад боломж байна. Харин түүнээс дээш тариалах нөхцөлд үрлэгч, хавагч, хамгийн гол нь үр тариа хураах комбайн онцгойлон дутагдаж байна. 2011 онд авсан бага оврын "John Deer" комбайн нэгдүгээрт хүчин чадал хүрэлцэхгүй 4 м

өргөн авцтай, хоёрдугаарт 1970, 1980 аад оны СК-5 комбайнууд үнэндээ хуучирч сэлбэг хэрэгсэл маш их зарцуулж засвар хийх давтамж олон ашиглахад маш хүнд болж байна аа. Хүмүүсийн ихэнх цаг хугацааг эдгээр техникийг засах, сэлбэг хайх, ихээхэн хөрөнгийг сэлбэг худалдан авахад зарцуулж байна. Ийм техникээр үйл ажиллагаа явуулахад нэгжийн өртөг өсч ашиггүй ажиллах нөхцөл болсоор байна. Мэдээж хөрөнгө санхүүгийн боломжоо харах байх, гэхдээ ойрын хугацаанд нэг шинэ комбайн худалдан авах шаардлага гарцаагүй болоод байна.

Тариалангийн үйл ажиллагааны хувьд зарим зүйлүүдийг хийж гүйцэтгэж төгс ажиллагаанд орууллаа. Үтрэм дээр олон хүн ажилладаг, үр тариаг олон шат дамжлагаар цэвэрлэдэг байсныг дотоодын нөөц бололцоогоо дайчлан ажлын чөлөөт цагаар ажиллагсадаа зохион байгуулан ажилласнаар сүүлийн жилүүдэд хийсэн ажлын үр дүн гарч талбайгаар ирсэн бүүдайг нэг удаагийн цэвэрлэгээгээр стандартад тэнцүүлдэг болголоо. 2017 оноос хойш тасралтгүй сайжруулснаар үтрэм дээр 2 хүн ажиллаж цаг, эрчим хүч, хөдөлмөр хэмнэн бүтээгдэхүүнийхээ чанарыг ахиулсан пункт ашиглалтад бүрэн орууллаа. Энэ байгууламжид зөвхөн өөрийн хуучин хаягдал техник төхөрөмж ашиглан , дотоод хүнийхээ нөөцөөр гүйцэтгэсэн нь Орхон сумын тариалан эрхэлдэг аж ахуй дундаа одоохондоо цор ганц үр ашигтай ажилладаг пункт болоод байна.

Мөн үр тариа хадгалах зориулалт бүхий 1974 онд ашиглалтад орсон 47 жил үрсгал засвар хийлгүй ашиглаж байгаа үр хадгалах агуулахаа засварлаж, нэг талд нь үр хадгалах, нөгөө хэсэгт нь трактор комбайнаа хадгалдаг болгож өргөтгөлөө. Энэ бүхнийг мөн өөрсдийн хөрөнгө , ажиллах хүчээр гүйцэтгэсэн болно.

Манай компаний хувьд тариалангийн талбайд мал орох өндөр эрсдэл байдгийг та бид мэднэ. Бүх гишүүдийн хүрал болон ТУЗ өөс өгсөн үүргийн дагуу энэ талаар тасралтгүй ажиллаж Хөтөл талаас мал орох эрсдэл бүхий 332 га талбайг, мөн 42-р зөрлөг талаас мал ордог 126 га талбайг хашаажуулж хамгааллаа. Эрдэнэт-Улаанбаатарын зам компаний эзэмшил газар нутаг дээгүүр дайран өнгөрдөг болсоноос хойш тариалангийн талбай дундуур туучих, шавар тойрох гэж тариа сүйтгэх явдал гарсаар байна. Энэ байдлаас хамгаалж 126 га талбайг дагуулан гүнзгий гуу татаж машин орох нөхцөлийг хаалаа. Эдгээр ажлуудыг мөн л өөрийн боломж нөхцөлөө дайчлан ажилчдынхаа хүчээр хийлээ. Өөрөөр хэлбэл үр тариа тарьж хураах технологит ажлаас бусад хүчин зүйл болох талбайг малаас хамгаалах, богино хугацаанд бага зардал цөөн хүний нөөцөөр үтрэмийн үйл ажиллагаа цомхотгосон хэлбэрт шилжүүлэх, техник болон үрээ хадгалах агуулахаа сэлбэж шийдвэрлэ чадлаа. Энэ бол сүүлийн хэдэн жил дамнуулан хийсэн томоохон ажил байлаа.

2020 оны 7 сарын 23 ны өдөр гэнэтийн хуй салхи босч зэрэгцээ компаний 15*50 метр хэмжээний техникийн сарай тэр чигээрээ агаарт 150 гаран метрт хөөрч манай компаний хашаанд эгнүүлэн тавьсан үрлэгч, тариа хураах жатканы дээр унаж бүрмөсөн ашиглах боломжгүй болгосон. Одоо хаврын тариалалтад үрлэгч дутна, түүнийг сэлбэг материал олох засах гээд ажил гараад байна.

Төлөвлөсөнөөр ажил хийгдэж байгаа учраас техникийн бэлэн байдал бусад шаардагдах тоног төхөөрөмж, ажлын уялдаа, хүмүүсийн идэвхи хэвийн байна. Үйл ажиллагааны хувьд танилцуулахад ийм байна.

С.Бүрэнбат:

Санхүүгийн үйл ажиллагааны талаар залгуулж сонсоод нэг мөр саналаа хэлээд явах уу.

Б.Нямбаяр:

2020 онд гарсан санхүүгийн аудитлагдсан тайлангаар нийт хөрөнгийн дүн 576 682 432,0 , нийт өр төлбөрийн дүн 313 475 200,0 төгрөг байна. 2020 оны үйлдвэрлэл явуулахад ХААН банкнаас 100 000 00 төгрөгөөр нэг удаа, нэмж 30 000 000,0 намрын ургац хураалтад зориулан авч хэрэглэв. Ер нь банкнаас авсан зээлээ жилд нь багтааж төлөөд банкны хувьд он дамжсан зээлийн өглөггүй явж байгаа. Хаврын тариалалтад нөөцөлсөн үр хүрэлцэхгүй Улсын нөөцийн газраас 50 тн үрийн будаа 30 хувийн урьдчилгаа төлж авсан. Тариалж хураасан будааны орлого 157 925 856.0 төгрөг байна. 2020 онд улсын хэмжээнд ургац буурч Орхон сумын дундач 7,0 цн ургац байсан. Манай хувьд бохир жингээр 7,8 цн ургац авсан юм. Үр тариалсанаас хойш 40 гаран хоног хүр бороогүй уриншийн чийг хүрэлцэхгүй тариан түрүү доод талаасаа навч шарлаж байхад бороо залган орсон. Бороо орж эхлэснээс хойш тасрахгүй орж масс ихээр ургаж ургац тогтоох үеэр 14 цн орчим баримжаа харагдаж байсан ч болц гүйцэхэд хоосон түрүү болж ургац буурчээ. Ер нь Сэлэнгэ аймгийн хувьд 6 сард алаг цоог бороо орсоноос бусад талбай жигд тааруу ургац авсан юм байна.

Гарсан зардлууд үрийн буудайн урьдчилгаа 12 525 000 , цалинд 34 310 000, НДШимтгэлд 6 144 000 , цахилгааны зардалд 3 104 354, татварт 2 800 921, сэлбэг хэрэгсэл 15 744 600, шатах тослох материал 29 783 310 , тээврийн зардал 4 373 840 , гумат бордоо 3 200 000, хоол хүнс албан томилолтын зардал 9 912 992, хөдөлмөр хамгааллын зардал 442 000, зээлийн хүү 13 800 000, үрийн будааны зөрүү үнэ 6 130 130, гэрээт харуулын зардал 600 000, зээл авсан бэлэн мөнгөний шимтгэл 1 300 000, рапсны үр 4 850 000, даатгалд 450 000 зэрэг төрлийн 337 624 623 төгрөгийн зардал гарчээ.

Тариалсан талбайгаас цэвэр жингээр 363 тн ургац авч Өгөөж гурил компанид 243 тн ыг 660 000 төгрөгөөр борлуулж 158 400 000 төгрөгний борлуулалт хийв. Мөн Алтантэриа ХХК ий өглөг 11 800 000 төгрөгт 20 тн буудай, УНГазарт үрийн будааны өглөг 50 тонн 29 500 000 төгрөгийн өглөг хаалаа. Өөрийн үрэнд 50 тн будаа цэвэрлэлгүй авч үлдэв.

Оны төгсгөл дээр 3 хувийн хүүтэй зээлд хамрагдан 240 000 000 төгрөгийн зээл авч уг онд авсан 130 000 000 төгрөгийн зээлийг хааж , банк зээл олгосон бэлэн мөнгөний шимтгэлд 2 400 000 төлж буцаан төлөлт гэж 45 000 000 хэрэглээгүй байхад буцаан суутгаж, 1 800 000 төгрөгийн зээлийн хүү төлсөн байна.

Өглөгөөс Агромаш компанид тракторын үнийн үлдэгдэл 25 000 000, Улсын нөөцийн газарт үрийн будааны үлдэгдэл 6 160 130, Тариалан дэмжих санд 16 200 000, иргэн Нямбаярт комбайны үнийн үлдэгдэл 10 800 000, улсаас олгодог урамшуулал 15 668 400 төгрөгийн

авалгүй өрөндөө суутгуулжээ. Одоо Агромаш компанид 10 000 000, ХААДСанд 24 000 000, иргэн Нямбаярт 79 200 000 төгрөгийн өглөг байна. Тайлангийн дэлгэрэнгүйг та бүхэнд явуулсан байгаа.

Б.Баярхүү:

За тайлангуудыг сонслоо. Үйлдвэрлэлийн асуудлууд нилээд бодитой зүйл ярилаа. Нөөцөө шавхаж нилээд зүйлүүд амжуулсан юм байна, өнгөрсөн хугацаанд өгөгдсөн үүргүүд биелэгджээ. Харин ургацын хувьд тааруу байна даа. Ер нь хөрсний чанараа анхаарахгүй бол дан ганц хур борооны асуудал биш байх. Хөрсөнд шинжилгээ хийлгэж ямар бордоо хэрэгтэйг тодорхойлж бордоо хэрэглэх шаардлага гарч байна. Хоёрдугаарт тарилтын гүн, үрийн чанарыг онцгойлон анхаарахгүй бол болохгүй. Комбайн муу учраас хураалтдаа хугацаа алдаж тариа хорогдоод байгаа тал байгаа. Цаашид өөрсдөө тракторч комбайнчин бэлтгэх талаар идэвхитэй ажиллаач, одоо ажиллаж байгаа хүмүүс нас нилээн явсан байна. Энэ онд тэр зээл аваад өрийн ачаалал нилээд өсөх нь, зардлаа хянаж бүх ажлаа цомхон хийх хэрэгтэй. Зээлийг цаашид сунгах хүсэлт компаниуд гаргадаг л юм, гэхдээ банк сунгах эсэх нь эргэлзээтэй. Одоо тариалалтаа маш чанартай хий, технологийн алдаа гаргахгүй бай, хугацаа алдаж ердөө болохгүй шүү.

Г.Нарантуяа:

Тариалангийн ажил жил бүр хүндрэх юмаа. Будааны үнэ чөлөөлөхгүй сүүлийн 10 аад жил нэг үнээр явж байна. Энэ хооронд валютын ханш нэг нугарч байна, тос масло сэлбэг хэрэгсэл бүгд гадаадаас валютаар. Жаахан ургац авах юм, зардал чирэгдэл бүгдийг нь хэмнээд ашигтай ажиллаж чадах юм уу цаашдаа. Хэр хэмжээгээрээ л зүтгэж байна энэ хамт олон, арай гэж цалин залгаж л амьдарч байна. Энэ жил хавар эрт бороо орж чийг сайхан байна, жаахан ахиухан тариад азаа үзье гээд хөдөлж байна. Ажлын арга барил, зардлын хэмнэлт энэ тэр бол болж байна аа. Олон жил дараалж гарсан зардлаа нөхөж чадахгүй болохоор шантрах маягтай болж байна. Комбайн, үрлэгч хавагчаас бүсдэг нь ч шийдчихээд байна, жаахан тариа авбал юуны түрүүн нэг комбайн авья гэдэг маш зөв. Зориг гаргаад авах шаардлага байна. Аль болохоор өр төлбөрийн дарамтгүй байя гээд цалингаа нэмж чадахгүй өр барагдуулж байна шүү.

С.Бүрэнбат:

Тариалангийн үйлдвэрлэлийн төрийн бодлогод дүү хоолой нэмж байх хэрэгтэй байна, компаниас янз бүрийн хурал цуглаан уулзалтад оролцохгүй мэдээллээс хоцрох, бодит байдлаа ойлгуулж чадахгүй байгаа дутагдлууд гүйцэтгэх удирдлагад байна. Өнгөрсөн жил гэхэд үрийн будаагаа хрөөцөлдөхгүй хоцорч цаг нь тулгасан асуудал гарсан. Юм юманд овсгоотой хурдан шуурхай ажиллах хэрэгтэй. Хоцрох тусам л алдаа нэмэгдэнэ шүү. Өнгөрсөн зун энд зуссан, тариа будааны болц талаар сайн ойлгож байна. Ингээд байвал бага цалинтай гээд ажилчид ч тогтохгүй болж хувирна. Үнэнийг хэлэхэд 3 механикжуулагч сайн ажиллаж байгаа, хааяа нэг архи уусныг эс тооцвол. Бригадын орчимд архи согтууруулах ундааг бүрмөсөн хориглоорой. Өнгөрсөн оны үйл ажиллагаа, санхүүг нөөц бололцоогоо дайчилж

боломжийн ажилласан гэж үзэж байна. Бусад компаниудын дунджаас багахан ч дээгүүр ургац авсан. Энэ онд сайн ажиллаж санхүүгээ хэвийн болгож авья.

Ө.Батсайхан:

За тарианы амьдрал хэцүү юм байна гэдгийг биеэрээ мэдэрч байна. 24-25 жил үр тарианы ая харж амьдарлаа. Олон зүйлээс шалтгаалж байна. Уг нь гайгүй л ажиллаад байх шиг байх юм. Цаашид сайн анхаарч ажиллаарай. Би өөрийн эзэмшиж байгаа хувиа дүү нартаа бэлэглээ гэж шийдсэн. Хууль ном нь ямар байна гэрээ юмаа хийгээд шилжүүлээд ав миний дүү нар. Бие бас жаахан өвчин ээрч байна та нарт одоо ирж очоод явж чадахгүй шинжтэй. Хүр бороо тэгширч сайхан ургац авах цаг ирэх байлгүй дээ. Нараа энэ талаар судлаад энэ ондоо багтаагаад миний жаахан хувийг өөрсдийн болгоод аваарай. Чадалтай болоод ирэхээрээ биднийгээ харж үзнэ биз дээ.

С.Бүрэнбат:

Санал хэлж дууслаа. Одоо 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хангалттай гэж үзье гэсэн санал хураалт явуулья. Бүгд дэмжиж байна. Тогтоол гаргая. Мөн энэ оны орлогоос нэг комбайн авах зөвшөөрөл олгоё.

Хурал 3 цаг үргэлжилж 17 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэл бичсэн



Ө.Батсайхан

Хянасан хурал даргалагч



С.Бүрэнбат